



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 19 өдөр

Дугаар А/431

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4-ийн "а" дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй Цаст-Алтай цогцолбор сургуулийн сурагчдын үдийн хоолны заалны сурагч ширээ, сандал хүлээж авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч: Б.Даваадорж - Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Гишүүд

Б.Түмэнжаргал - Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн

П.Алтанлхагва - Цаст Алтай цогцолбор сургуулийн захирал


Д.Нямдорж - Боловсрол, соёл урлагийн газрын төсөв
хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн

Нарийн бичгийн

дарга: Ж.Батбаяр - Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн

2. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй Цаст-Алтай цогцолбор сургуулийн сурагчдын үдийн хоолны заалны сурагч ширээ, сандлыг гэрээнд заагдсан нөхцөл, шалгуур ажлын даалгаврын дагуу шалгаж хянан баталгаажуулж шийдвэр гаргахыг ажлын хэсгийн ахлагч /Б.Даваадорж/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ



Т.ДЭЛГЭРСАЙХАН